

ТҮРЭЭСИЙН ТӨЛБӨР ЦУГЛУУЛАХ ҮЙЛЧИЛГЭЭ

ТҮРЭЭСИЙН ТӨЛБӨР ЦУГЛУУЛАХ ҮЙЛЧИЛГЭЭ

Түрээсийн гэрээн дээр үндэслэдэг хоёр талын харилцааг **ТӨГТМОЛ ШИЛЖҮҮЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ** тусlamжтайгаар бататгаж, түрээслэгчийн өдөр болгоны орлого/пос-ын орлогоос тодорхой дүнгээр хуриитал үүсгэн, сар болгоны төлбөрийн өдөр түрээслүүлэгчийн данс руу автоматаар төлбөрийг шилжүүлэх үйлчилгээ юм.

Түрээс цуглуулах үйлчилгээнээс бий болох боломж


ТҮРЭЭСЛҮҮЛЭГЧ	ТҮРЭЭСЛЭГЧ
<ul style="list-style-type: none">Гэрээний дагуу тогтсон хугацаандаа түрээсийн орлогоо эрсдэлгүй авах боломж үүснэ.	<ul style="list-style-type: none">Сар тутмын өндөр дүнтэй түрээсийн төлбөрийн дарамтаа бууруулах.Шимтгэлгүй
<ul style="list-style-type: none">Харилцагчийн бизнесийн мөчлөгт тулгардаг төлбөрийн асуудал, дарамт болон харилцааны асуудлыг автоматаар шийдэж өгч буй бүтээгдэхүүн үйлчилгээ	

	ТҮРЭЭСЛҮҮЛЭГЧ	ТҮРЭЭСЛЭГЧ
Үйлчилгээний хураамж	*1 сар -50,000 төгрөг /Түрээслэгчийн тооноос үл хамааран/	-
Тогтмол шилжүүлэг Үйлчилгээний шимтгэл	-	Шимтгэлтгүй
Мэдэгдлийн Үйлчилгээний шимтгэл	-	ХШЕН-ын дагуу - Утасны дугаар -50 төгрөг - И-мэйл - Шимтгэлтгүй

*Нээлтийн урамшуулал зарлаж 2022 оны 03-р сарын 31-ний өдөр хүртэл хамтын ажиллагаа байгуулсан Түрээслүүлэгчийг үйлчилгээний эхний 12 сарын хураамжаас чөлөөлнө.

Бусад нөхцөл

- Түрээслүүлэгчтэй ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭ хийсний үндсэн дээр түрээслэгч нарыг үйлчилгээнд бүртгэнэ.
- Тогтмол шилжүүлэг үйлчилгээний бүртгэлийг Онлайн банк ашиглан устгах, өөрчлөх боломжгүй.
- Тус үйлчилгээг 2 талын зөвшөөрлийн дагуу цуцална.
- Үйлчилгээг цуцлахад шимтгэлгүй.



ТАВИГДАХ ШААРДЛАГА:

Харилцагч талуудын хооронд байгуулсан Түрээсийн гэрээ нь банканд бүртгэх өдрөөс хойш доод тал **3 сар ба түүнээс дээш хугацаанд** байх.

Түрээслэгч:

- Түрээслэгчийн хувьд Банкны дансаар түрээсийн төлбөр төвлөрүүлэх орлогоо дамжуулах.
- Банканд дансгүй Түрээслэгчийн хувьд шинээр данс нээлгэж орлого, түрээсийн төлбөрөө дамжуулах

Түрээслүүлэгч:

- Түрээслүүлэгчийн хувьд Банкны дансаар түрээсийн төлбөрийг хүлээж авах.
- Банканд дансгүй Түрээслүүлэгчийн хувьд шинээр данс нээлгэж түрээсийн төлбөрөө хүлээн авах



ТҮРЭЭСЛЭГЧ ТАЛЫН БҮРДҮҮЛЭХ МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ

Иргэний хүсэлтийн хувьд:

- Харилцагчийн хүчин төгөлдөр Монгол Улсын иргэний үнэмлэх эсхүл гадаад паспорт;
- Хуримтлалын үйлчилгээний хүсэлт
- Харилцагч талуудын хооронд байгуулсан Түрээсийн гэрээний хуулбар;

Байгууллагын хүсэлтийн хувьд:

- Байгууллагын албан хүсэлт
- Хуримтлалын үйлчилгээний хүсэлт
- Харилцагч талуудын хооронд байгуулсан Түрээсийн гэрээний хуулбар;

Харилцагч та банканд бүртгэлгүй бол салбарт хандан дансаа нээлгээрэй.



ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК

ДЭЛГЭРЭНГҮЙ МЭДЭЭЛЛИЙГ:

Утас: +976 1900-1977

И-мэйл: info@tdbm.mn

Вэб хаяг: www.tdbm.mn